

## ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН МЭДЭЭ (2023 оны 02 дугаар улирлын байдлаар)

2023 оны 06 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/1049 дугаар захирамжаар батлагдсан "Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ын дагуу ажиллаж байна.

### Нэг. Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн мэдээ

Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас нийт 115 өргөдөл ирснийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем /<https://erp.ulaanbaatar.mn> /-д бүртгэн, 115 өргөдлийг бүрэн шийдвэрлэж хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 0 цаг 48 минут бөгөөд хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй байна.

### Хоёр. Өргөдөл, гомдлын хандалтын мэдээ (өссөн дүнгээр)

2023 оны 2 дугаар улирлын байдлаар байгууллагад ирсэн өргөдлийн хандалтыг төрлөөр нь ангилбал:

- Ажлын сахилга, хариуцлагын тухай-2
- Нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай (иргэнээс)-2
- Ажилд шилжин, дэвшин ажиллах тухай өргөдөл-4
- Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл- 11
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл- 13
- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл- 18
- Захиргааны чөлөө хүссэн өргөдөл-24
- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл- 41

Өргөдөл гомдлын төрлийг нийт өргөдөлд эзэлж буй хувиар нь үзүүлбэл:



График 1. Өргөдлийг төрлөөр нь ангилсан байдал.



**Гурав. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг өмнөх үетэй харьцуулсан байдал**

Д/д	Хугацаа	Хүснэгт 1	
		2022.02 улирал	2023.02 улирал
<b>Ерөнхий үзүүлэлт</b>			
1	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	10 хоног 23 цаг 1 минут	6 хоног 0 цаг 48 минут
2	Хандалтын тоо	114	116
3	Зөрчлийн үзүүлэлт	13	9
<b>Өргөдөл гомдлын хандалтын төрөл</b>			
4	Иргэнээс гаргасан санал, хүсэлт	1	2
5	Ажлын сахилга, хариуцлагын тухай	0	2
6	Ажилд шилжин, дэвшин ажиллах тухай өргөдөл	3	4
7	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл	11	13
8	Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл	12	11
9	Захиргааны чөлөө хүссэн өргөдөл	16	24
10	Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл	42	41
11	Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл	29	18

**Дөрөв. Өргөдөл гомдлын бүртгэлийг төрлөөр нь ангилбал:**

Хүснэгт 2

Д/д	Бүртгэлийн төрөл	Тоо
1	Талархал	0
2	Санал	0
3	Хүсэлт	114
4	Гомдол	1
5	Мэдэгдэл	0
6	Зөрчил	0

**Дүгнэлт:**

Графикаас харахад газрын хэмжээнд 2023 оны 2 дугаар улиралд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоногоор мөн зөрчлийн тоон үзүүлэлт 30 хувиар буурсан байна.

Ажилтан, албан хаагчдаас ирсэн өргөдөл, гомдлыг тухай бүр дотоод удирдлагын /<https://erp.ulaanbaatar.mn> / бүртгэлийн системд байршуулан технологийн шийдэл ашиглан, шийдвэрлэлтийн явцыг ил тод, шуурхай байлгах зорилгоор явцын тэмдэглэлийг 10 хоног тутамд хөтлөн, 2 удаагийн шат дамжлагатайгаар шийдвэрлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд манай байгууллагад хамааралгүй 1 өргөдөл ирсэн бөгөөд холбогдох байгууллагад нь өдөрт нь шилжүүлэн ажилласан.

ТАЙЛАН ХЯНАСАН:  
ДОТООД ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ  
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:  
ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ  
ХАРИУЦСАН АЖИЛТАН

А.НОМИНЗУЛ